

АРВИЖИХ ХУВЬЦААТ КОМПАНИ

2020 оны 3 дугаар сарын 21-ны өдөр

№20/01

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ШИЙДВЭР

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59.4-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын”-ын дагуу 2020 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн ТУЗ-ийн гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Сүхбаатар дүүрэг, 3-р хороо Сөүлийн гудамж, Сөүл плаза 406 тоот 15⁰⁰ цагт хуралдуулсугай.
2. Арвижих Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
 1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 2. Компанийн 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт;
 3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
 5. ТУЗ-ын ердийн болон хараат гишүүдийг сонгох;
 6. ТУЗ-ын 2020 оны цалин урамшууллын төсөв батлах;
 7. Ноогдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;
3. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай. Үүнд:
 - Комиссын дарга: Б.Эрдэнэбат
 - Комиссын нарийн бичиг: Ш.Уянга
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Д.Баатар, нарийн бичгийн даргаар Б.Дэмбэрэл нарыг тус тус томилсугай.
5. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - Комиссын дарга: Б.Дэмбэрэл
 - Гишүүд: Ш.Уянга, Б. Энхбат
6. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар

хүргэх журам”-ын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх болон хурал зохион байгуулахыг хурлын комисст даалгасугай.

7. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн тухай хуулийн 64.2-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын”-ын дагуу 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
8. Хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
9. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах ” Саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
10. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 17.00 цагаар тасалбар болгосугай.
11. Хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Арвижих ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгахаар тогтоосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



/Д.БААТАР/